

# 2-р жишээ: Клэйр—Их Эзэний хүссэн зүйлийг гүйцэтгэхэд миний гаргах хүчин чармайлт хангалттай байх болов уу? (Иохан 6:5–14)

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Есүс мөн Түүний шавь нар үй олон хүн өөрсдийг нь чиглэн ирж буйг олж харах үед шавь нар нь хүн бүрийг хооллох хангалттай хоол байхгүй гэж эмээж байлаа.

Иохан 6:5–14 дээрх, Есүс 5000 хүнийг хооллож буй түүхийг судлахдаа **биднийг байгаа бүх зүйлээ Аврагчид зориулахад Тэр Өөрийнх нь зорилгыг гүйцэлдүүлэхэд бидний хүчин чармайлтыг арвижуулах болно** гэсэн зарчмын нотолгоог хайж олж, тэмдэглэ.

- Энэ зарчмыг дэмжих юуг та эдгээр шүлгээс олж мэдсэн бэ?
- Шавь нар эсвэл залуу хүү юугаа зориулах талаарх өөрсдийн үзлийг яг зориулах хэрэгтэй байсан зүйлтэй харьцуулах үед тэдэнд ямар бодол төрсөн гэж та бодож байна вэ?

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн нэгдүгээр зөвлөх Мишэлл Д.Крэйг эгчийн дараах мэдэгдлийг уншина уу.



Таны авьяас чадвар, бэлгүүд өмнө тань байгаа үүрэг даалгаварт хангалтгүй гэж танд санагдаж байсан уу? Би тэгж мэдэрч байсан. Гэхдээ та бид өөрсдөдөө байгаагаа Христэд өгч чадах ба Тэрээр бидний хүчин чармайлтыг илүү үр дүнтэй болгоно. Хэрэв та Бурханы ач ивээлд найдах юм бол хүмүүний дутагдал, сул талууд байсан ч гэсэн таны өргөл болгох зүйл хангалттай их байх болно. (Мишэлл Д.Крэйг, “Өөрсдийн бурханлаг байдалд сэтгэл дундуур байх нь,” *Ensign*, Nov. 2018, 54 эсвэл 2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 127)

- Бид өөр ямар арга замаар “байгаа зүйлээ Христэд өгч” болох вэ?
- Есүсийн 5000 хүнийг хооллож буй энэ түүхээс, өгч чадах зүйл нь хангалтгүй байх вий гэж санаа зовж буй хүнд туслах ямар зүйлийг та олж мэдсэн бэ?

Олж мэдсэн зүйлээ хуваалцахаар бэлтгэхдээ, Аврагч Өөрийнх нь зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд гаргасан хүчин чармайлтыг нь арвижуулж байсныг харсан өөрийн эсвэл бусдын амьдралын жишээг бод.